

**Удирдах ажилтнуудын 01 дүгээр сарын 03-ны өдрийн
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлт**

2022 оны 01 дүгээр сарын 31

№	Өгөгдсөн үүрэг, даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1.	2021 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ	2022.02.01-ний өдрийн дотор	Бүх байгууллагын дарга нарт	2021 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг нийт 33 удирдах албан тушаалтан мэдүүлэг өгөхөөс 30 удирдах албан тушаалтан мэдүүлгээ мэдүүлсэн байна. Босоо удирдлагатай 9 байгууллага дээд газартаа ХАСХОМ мэдүүлгийг мэдүүлсэн байна. ХАСХОМ мэдүүлгээ мэдүүлээгүй байгаа удирдах албан тушаалтнууд: БОАЖГазрын дарга Д.Мөнх-Эрдэнэ, Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мөнх-Од, ХХААГазрын дарга Н.Даваахүү	90.9
2.	Нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах, хуваарилагдсан газрыг цэвэрлэх	2022.01.31-ний өдрийн дотор	Сумдын Засаг дарга нар, Бүх байгууллагын дарга нарт	Сүмбэр сумын ЗДТГазар-Сумын 1,2,3-р багийн иргэдийн их цэвэрлэгээг сумын ЗДТГ-ын албан хаагчид хэсэгчилэн хуваагдаж зохион байгууллаа. 1-р баг 29 айл өрх, 2-р баг 36 айл өрх, 3-р баг 32 айл өрх цэвэрлэгээнд хамрагдлаа. 1-р багийн Төмөр замын дан байрууд, Ган замчин хотхон, Залуучуудын өргөн чөлөөний пункер болон том оврын чулуу, хавтанг ачуулж төвлөрсөн хогийн цэгт 75 тонн хог хаягдлыг тээвэрлэж төвлөрүүллээ. Шивээговь сумын ЗДТГазар- Сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн “Нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай” А/35 дугаар захирамжийн дагуу 1, 2-р багийн бүх нийтийн их цэвэрлэгээг 2022 оны 01 сарын 21, 22-нд зохион байгуулж нийт 23 аж ахуй нэгжийн 93 иргэн оролцож 4,8 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн. Баянтал сумын ЗДТГазар-16 дугаар зөрлөг дэх хогийн цэгийн хогийг цэвэрлэж гүйцэтгэсэн нийт 5 байгууллага оролцож 5 тн хог хаягдлыг цэвэрлэсэн. Нийт 32 байгууллага хуваарилагдсан газрыг цэвэрлэсэн. Цэвэрлэгээнд гараагүй-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх 0425 дугаар нээлттэй хорих анги,	93.7
3.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган	14 хоног тутам	Сумдын Засаг дарга нар, Бүх байгууллагын дарга нарт	Нийт 35 байгууллага Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээн авч хэрэгжүүлэх арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хянуулахаар харьяа хэлтсүүддээ өгсөн байна. ХХААГ, ГХБХБГ, “Талын Илч” ОНӨҮГ, Нийтийн номын сан, Шивээговь сумын ЗДТГ зэрэг байгууллагууд Байгаль орчин	31.4

	хэрэгжүүлж 14 хоног тутам БОАЖГ-т тайлан мэдээ ирүүлэх			аялал жуулчлалын газарт 14 хоног тутмын тайлан мэдээг хүргүүлэн ажилласан байна.	
4.	Уламжлалт монгол бичгээр төрийн албан хэрэг хөтлөлтийг явуулах, Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган Монгол хэлний бодлогын салбар зөвлөлд тайлан мэдээг ирүүлэх тухай	2022.01.31-ний өдрийн дотор	Сумдын Засаг дарга нар, Бүх байгууллагын дарга нарт	Тухайн арга хэмжээг 35 байгууллага байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хянуулахаар харьяа хэлтсүүддээ өгсөн байна. Соёл урлагийн газар, Нийтийн номын сан зэрэг байгууллагууд Монгол хэлний бодлогын салбар зөвлөлд 14 хоног тутмын тайлан мэдээг хүргүүлэн ажилласан байна.	24.5
Биелэлтийн дундаж хувь					60.1

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

Үүргийн биелэлт ирүүлээгүй байгууллагууд:

ШШГГазар, ШШАлба, ГБХЗХГазар